

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2016 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², Нийгмийн даатгалын тухай хууль³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2016 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	1,329,851.1
	1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	463,849.7
	1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	538,590.8
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	160,845.0
	1.4.Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	0.5
	1.5.Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	29.5

¹Төсвийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

²Төсвийн тогтвортой байдлын тухай "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

³Нийгмийн даатгалын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

	1.6.Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	45,014.0
	1.7.Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	41,327.3
	1.8.Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	22,868.9
	1.9.Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	2,904.0
	1.10.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,101.7
	1.11.Бусад орлого	53,319.8
2	Сангийн сайд	321,643.8
	2.1.Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	321,643.8
	Нийт орлого	1,651,495.0

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	1,252,775.2
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	100,102.8
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	37,328.3
	1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	27,701.4
	1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	244,114.7
	1.6.Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	118.8
	1.7.Үйл ажиллагааны урсгал зардал	19,845.9
	1.8.Хөрөнгийн зардал	25,104.8
	Нийт зарлага	1,707,091.8

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

5 дугаар зүйл."Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 400,000.0 сая төгрөгөөр баталсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг